



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 09

Сүхбаатар сум

2024 оны 3 дугаар улиралд хийсэн санхүүгийн  
Хяналт шалгалтын дүнгийн тухай


Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан дараах төсвийн шууд захирагч /Сэлэнгэ аймгийн Татварын газар, Алтанбулаг, Сант, Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газар, Алтанбулаг, Сант, Зүүнбүрэн сумын ИТХ-ын ажлын алба/-ийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчлийн дүн, эрсдэлийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, арга хэмжээг авч хяналт шалгалтаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн төсвийн сахилга бат, үр ашиг, үр нөлөө, ил тод байдлыг ханган эрсдэлийн үнэлгээг бууруулан ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга:  Н.Лхагвадорж  
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:  Т.Мөнхзул  
(Ахлах дотоод аудитор)


Гишүүд:  Т.Одсүрэн  
(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)

Ө.Сувдаа  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

4324009009



Х.Мөнхжаргал  
(Санхүү төрийн сангийн хэлтсийн  
дарга)



Б.Янжинлхам  
(Хууль зүйн хэлтсийн дарга)



А.Дашбат  
(Иргэний төлөөлөл)



А.Гэрэлмаа  
(Иргэний төлөөлөл)

Дотоод аудитын хорооны 2024 оны 10 дугаар сарын 22 ны  
өдрийн 09 дугаар тогтоолын хавсралт

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

(мян.төг)

д/д	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчлийн дүн	Эрсдэлийн үнэлгээ
1	Сэлэнгэ аймгийн Татварын газар	331,787.4	“Бага” эрсдэлтэй
2	Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газар	35,681.9	“Дунд” эрсдэлтэй
3	Сант сумын Засаг даргын Тамгын газар	18,188.6	“Дунд” эрсдэлтэй
4	Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газар	21,886.8	“Дунд” эрсдэлтэй
5	Алтанбулаг ИТХ-ын ажлын алба	7,178.1	“Дунд” эрсдэлтэй
6	Сант ИТХ-ын ажлын алба	2,912.6	“Бага” эрсдэлтэй
7	Зүүнбүрэн ИТХ-ын ажлын алба	18,303.0	“Дунд” эрсдэлтэй
<b>Дүн</b>		<b>435,938.4</b>	